



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2016 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 1/446

Булган

Дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 234 дүгээр тушаал, Булган сумын ИТХ-ын 2015 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Газар зохион байгуулалтын 2016 оны төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Булган аймгийн Булган сумын 6-р баг Тэрэм дэлгүүрийн баруун талд авто засварын зориулалтаар олгох 700 метр квадрат газрын анхны үнийг 4200000 /дөрвөн сая хоёр зуун мянга/ төгрөгөөр тогтоон газрын дуудлага худалдааг зохион байгуулсугай.
2. Дуудлага худалдаагаар олгогдох газрын байршлыг харуулсан схем зургийг хавсралтаар тогтоосугай.
3. Дуудлага худалдааг 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 14.00 цагт товлож, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулан явуулахыг ажлын хэсэг /Ч.Балдандорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Булган аймгийн Засаг даргын 2016 оны . . . дугаар сарын
. . . -ний өдрийн . . . дугаар захирамжийн хавсралт



Булган сумын 6-р баг "Тэрэм" дэлгүүрийн баруун талд байрлалтай авто засварын зориулалтаар олгогдох газрын байршлыг харуулсан зураг

